

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

3.БУЯНТ
2024 оны 10 дугаар сарын 24 өдөр

ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨГ ТЭЭВЭРЧДИЙН ГУДАМЖТАЙ ХОЛБОСОН АВТО ЗАМ,
ГҮҮРИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 10 дугаар сарын 24 өдөр

№. 24-9/15

Улаанбаатар хот


Энэхүү ажил нь иргэд эрүүл, аюулгүй, цэвэр орчинд амьдрах, ажиллах, халтиргаа гулгаагүй, аюулгүй зорчих нөхцөлийг хангахад чиглэнэ.

Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэхдээ замын хөдөлгөөнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй, аюулгүй байдлыг хангуулан ажиллах шаардлагатай.

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоол - Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/665 дугаар захирамж
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд шинээр ашиглалтад орсон Чингисийн өргөн чөлөөг Тээвэрчдийн гудамжтай холбосон авто зам, гүүрийн цэвэрлэгээ, үйлчилгээ
3	Ажлын тоо хэмжээ	- Нийт 22700 м.кв зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан тариф, дүүргийн Засаг даргын 2024 оны А/665 дугаар захирамжаар батлагдсан давтамжийн тоогоор хийж гүйцэтгэж, тухай бүр тайлагнаж ажиллана.
4	Одоогийн байдал	Тус авто зам 2024 онд шинээр ашиглалтад орсон бөгөөд дүүргийн Засаг даргын Засаг даргын 2024 оны А/665 дугаар захирамжаар гүйцэтгэгч шалгарч, гэрээ байгуулагдах хүртэл хугацаанд цэвэрлэгээ, үйлчилгээг Эко хотын тээвэр ААТҮГ-т хариуцуулсан.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хот нийтийн аж ахуй байх; - Тухайн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах хүний нөөц, техник хэрэгслийн хүчин чадалтай байх; - Ижил төстэй үйлчилгээг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохино. Үүнд 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил


		төстэй үйлчилгээг гүйцэтгэсэн байх (үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээ, комисс хүлээж авсан дүгнэлтийн эхээс хийсэн хуулбар);
8	Гүйцэтгэх ажлын тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> - Зам талбайн үйлчлэгчийн нэг удаагийн цэвэрлэх талбай 10000 м²-аас ихгүй байна. - Авто зам, гүүрийн цэвэрлэгээг зуны улиралд өглөөний цэвэрлэгээг 05:00-07:00 цаг, өвлийн улиралд 06:00-08.00 цагийн хооронд бүрэн цэвэрлэж авто машин, явган зорчигч саадгүй зорчих нөхцлийг хангана. - Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед ажлын цаг харгалзахгүй цэвэрлэгээг хийнэ. - Өвлийн улиралд хариуцсан авто замын халтиргаа гулгааг цас орсон даруйд нягтаршиж, мөстөхөөс өмнө халтиргаа, гулгаа арилгах тусгай зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэх; - Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээг дараах дарааллаар гүйцэтгэнэ. <ul style="list-style-type: none"> а. Автобусны буудлын цэвэрлэгээ, хогийн сав суллах; б. Авто замын зорчих хэсгийн дагуух цэвэрлэгээ; в. Явган хүний замын цэвэрлэгээ; г. Нийтийн эдэлбэр газрын эд хөрөнгө дээр наасан, зурсан зар сурталчилгааг хуулах, арилгах; д. Нийтийн эдэлбэр газар, гудамж, талбайн хогийн сав суллах е. Ногоон байгууламжийн түүвэр цэвэрлэгээ ё. Хайс, хашлага, архитектурын байгууламж угаах
9	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд</u></p> <ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын тухай хууль <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам" - "Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, авулгүй ажиллагааны удирдамж" UCS 1704A:2022 - Бусад холбогдох норм, дүрэм

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Г.ТУЯАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ,
БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Б.ЭРДЭНЭЗУЛ

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны дугаар сарын өдрийн дугаар ажлын даалгаврын хавсралт



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ

№	Ажлын нэр	Хороо	Эхлэл, төгсгөлийн цэгийн байршил	Талбай, м.кв	Тариф /төгрөг/	1 сард цэвэрлэх давтамж
1	2	3	4	5	6	7
1	Чингисийн өргөн чөлөөг Тээвэрчдийн гудамжтай холбосон авто зам, гүүрийн цэвэрлэгээ үйлчилгээ	3	Чингисийн өргөн чөлөөнд Алтаргана хотхоны баруун талын гэрлэн дохиотой уулзвараас Тээвэрчдийн гудамжтай холбосон Дунд голын гүүр (туслах замтай нийлэх хүртэл)	22700	70	9
Нийт				22700	70	9